

“ДАРХАН ХОТЫН СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН”ОНӨААТҮГ-ЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН СТРАТЕГИ, ХӨТӨЛБӨР ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАЖ ҮНЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмаар “Дархан Хотын Соёл Амралтын Хүрээлэн”ОНӨААТҮГ-ын хүний нөөцийн стратеги, албан хаагчдын ажиллах нөхцөл ниймийн баталгааны болон сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хүний нөөцийн бодлогын ажлын байр, албан тушаалд албан хаагчийг сонгон шалгаруулах, тохирсон ажил, албан тушаалд ажиллуулах, хөдөлмөрлөх таатай нөхцөлөөр хангах, ажилтны хөдөлмөрийг зөв хуваарилан ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, түүнд тохирсон цалин хөлс, шагнал урамшуулал олгох, хариуцлага тооцох, сургаж хөгжүүлэх, ажиллах нецел, нийгмийн баталгааг шийдвэрлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, цаашид байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагаанд баримтлан ажиллах чиглэлийг ытогтоох явдал юм.

Хоёр. Үнэлгээний зорилго, зорилт

- 2.1 “Дархан Хотын Соёл Амралтын Хүрээлэн”ОНӨААТҮГ-ын хүний нөөцийн стратеги, хөтөлбөр, баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны зорилго нь баримт бичгийн төлөвлөлт, биелэлтэд чанарын үнэлгээ хийх, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шийдвэр нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийх, үр нөлөөг үнэлэхэд оршино.
- 2.2 Хүний нөөцийн менежментийн гол зорилго нь албан хаагчийн мэдлэг, зөөлөн ур чадвар чадвар, нөөц боломжийг нээн илрүүлж хөгжүүлэх, санаачилгатай ажиллахад уриалах, байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй байх орчин нөхцөлийг бүрдүүлэх, чадварлаг мэргэшсэн албан хаагчийг бүрдүүлэх, тэднийг тогтвортой ажиллуулах, албан хаагчийн чадварыг бүрэн нээж, оновчтой ашиглахад чиглэгдэнэ.
- 2.3 “Дархан Хотын Соёл Амралтын Хүрээлэн”ОНӨААТҮГ-ын хүний нөөцийн бодлого нь шударга, эрх тэгш, эерэг таатай орчинг бий болгож байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд тулгуурлан байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, судалж сонгох, ажилд томилох, шилжүүлэн, сэлгэх ажиллуулах, сургаж хөгжүүлэх, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулах, тогтвортой үйл ажиллагааг хангах зэрэг хүний нөөцтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Гурав. Хяналт-шинжилгээ үнэлгээ хийх зарчим, хамрах хүрээ

- 3.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд дараахь зарчмыг баримтална:
- 3.1.1 шударга, хараат бус байх;
 - 3.1.2 хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа нээлттэй, гаргасан тайлан, дүгнэлт нь ил тод байх;
 - 3.1.3 хяналт-шинжилгээ, үнэлгээ нь шалгуур үзүүлэлт, тоо баримт, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;
 - 3.1.4 хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан дүгнэлт нь “Дархан Хотын Соёл Амралтын Хүрээлэн”ОНӨААТҮГ-ын хүний нөөцийн бодлого, үйл

- ажиллагааны үр дүн, үр нөлөө эрсдэлийг тодорхойлсон, нотлогдохуйц байх;
- 3.1.5 хяналт-шинжилгээ үнэлгээ хийхдээ гарсан шийдвэр, зохион байгуулсан арга хэмжээ, тайлан, албан хаагчийн оролцоог хангасан байх;
- 3.1.6 хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд хүний нөөцийн эрсдэл, бодлогын баримт бичгийн биелэлтийн үр дүн, цаашид анхаарах зөвлөмжийг гаргасан байх;
- 3.1.7 хяналт-шинжилгээ, үнэлгээг 2 жил тутамд хийнэ.
- 3.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээнд дараах хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилт багтана:
- 3.2.1 “Дархан Хотын Соёл Амралтын Хүрээлэн”ОНӨААТҮГ-ын хүний нөөцийн стратеги
- 3.2.2 “Дархан Хотын Соёл Амралтын Хүрээлэн”ОНӨААТҮГ-ын албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны төлөвлөгөө
- 3.2.3 “Дархан Хотын Соёл Амралтын Хүрээлэн”ОНӨААТҮГ-ын албан хаагчийн сургалтын хөтөлбөр
- 3.2.4 Хүний нөөцийн бусад баримт бичиг.

Дөрөв. Хяналт-шинжилгээ үнэлгээ хийх зохион байгуулалт

- 4.1 “Дархан Хотын Соёл Амралтын Хүрээлэн”ОНӨААТҮГ-ын хүний нөөцийн стратеги, хөтөлбөр, шийдвэрийн баримт бичгийн хэрэгжилтэд дараах үе шатаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ:
- 4.1.1 мэдээллийг цуглуулах, ангилах, нэгтгэх;
- 4.1.2 зорилтын биелэлтийн дүнг үнэлэх;
- 4.1.3 биелэлтийн үр нөлөөг үнэлэх;
- 4.1.4 гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөллийг үнэлэх;
- 4.1.5 төлөвлөлт, хэрэгжилтийн харилцан хамаарлыг үнэлэх;
- 4.1.6 биелэлтийн явц, үр дүнг үнэлэх;
- 4.1.7 баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах тодорхой санал, зөвлөмж боловсруулах.
- 4.2 Хүний стратеги, бодлогын баримт бичиг, түүний хэрэгжилттэй холбоотой бүхий л шийдвэр, нотлох баримт судалгаа, мэдээллийг хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж хугацаанд нь үнэн зөв, бүрэн бүрдэлтэйгээр Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжид хүлээлгэн өгнө.
- 4.3 Хүний нөөцийн стратеги, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний явцын болон эцсийн тайлан, санал зөвлөмжийг “Дархан Хотын Соёл Амралтын Хүрээлэн”ОНӨААТҮГ-ын дэргэдэх дотоод хяналтын зөвлөлд танилцуулна.
- 4.4 Журмын хэрэгжилтийн талаар байгууллагын удирдлага, албан хаагчид тодорхой санал хүсэлт гаргаж, журамд тодотгол хийж, нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Тав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг хэрэгжүүлэх

- 5.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, санал, зөвлөмжийг удирдлагад танилцуулан, гарсан шийдвэрийг “Дархан Хотын Соёл Амралтын Хүрээлэн”ОНӨААТҮГ-ын нийт албан хаагчдад танилцуулна.
- 5.2 Үнэлгээний дүгнэлт, тайлан, санал зөвлөмжийн хүрээнд хүний нөөцийн стратеги, хөтөлбөр, шийдвэрт нэмэлт өөрчлөлт оруулж болно.